

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮЕНЧ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/45/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: <a href="mailto:BoldbaatarKh@audit.gov.mn">BoldbaatarKh@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:Tsetsegsurena@audit.gov.mn">Tsetsegsurena@audit.gov.mn</a> Гэрээт Аудитор Н.Батжаргал Гэрээт аудитор: Д.Цогзол Утас: 70432545 цахим хаяг:</p>
-------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>БСУГ</i>	<i>Боловсрол, Соёл, урлагийн газар</i>
<i>НДШ</i>	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
<i>ХАОАТ</i>	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>
<i>СТСХ</i>	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>
<i>БШУЯ</i>	<i>Боловсрол шинжлэх ухааны яам</i>

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН төгрөгөөр .....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр.....	5
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр .....	6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр .....	8
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН төгрөгөөр .....	9
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа: Аудитын явцад 6335.3 мянган төгрөгийн Бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн, 1542.8 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын өглөг, нийт нийт 7878.1 мянган төгрөгийн алдааг тус тус залруулсан.....	14
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 3966.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	15
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	15

## 1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
64000 Цэмбэгэрав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ҮЕНЧ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Т.ТОГТОХБАЯР ТАНАА

2021.03.18 № 2/162  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Үенч сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсролын чанар, үр дүн, багшийн ёс зүй зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын Аудитын гол асуудал

Авлага өр төлбөрийг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй, бараа материалын тооллогыг цаг хугацаанд нь хийгээгүй, тооцоо бодоогүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг

021020655

гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Аудитын олон улсын стандарт-300 -ын "Оршин байх", "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ВОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>675,202,600.00</b>	<b>536,543,630.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>271,564,000.00</b>	<b>108,141,630.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	271,564,000.00	108,141,630.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	271,564,000.00	108,141,630.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	271,564,000.00	108,141,630.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>403,638,600.00</b>	<b>428,402,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	403,638,600.00	405,553,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,638,600.00	405,553,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	22,848,400.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	22,848,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>413,314,672.56</b>	<b>442,887,739.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>413,314,672.56</b>	<b>442,887,739.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	413,314,672.56	431,077,569.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	267,190,678.50	308,324,535.00
210101	Үндсэн цалин	260,385,996.00	306,523,791.00
210102	Нэмэгдэл	4,373,272.00	1,800,744.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,626,104.50	38,476,646.00
210201	Тэтгэврийн даатгал	33,626,104.50	38,476,646.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,036,899.98	25,223,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,557,723.00	2,338,284.00
210302	Түлш, халаалт	29,409,176.98	22,591,116.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	294,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,312,800.00	1,768,200.00
210401	Бичиг хэрэг	180,700.00	197,400.00

210402	Тээвэр, шатахуун	1,035,300.00	1,069,600.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	170,900.00	112,300.00
210404	Ном, хэвлэл	39,400.00	57,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,000.00	331,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>64,989,922.00</b>	<b>32,961,301.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,209,500.00
210502	Хоол, хүнс	64,221,222.00	30,197,101.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768,700.00	1,554,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,300.00</b>	<b>200,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,300.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,747,867.58</b>	<b>24,123,487.35</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,910,815.00	4,631,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,657,052.58	19,491,887.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>11,810,170.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>11,810,170.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,810,170.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>261,887,927.44</u></b>	<b><u>93,655,890.65</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>11,887,927.44</u></b>	<b><u>93,655,890.65</u></b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>403,638,600.00</u></b>	<b><u>428,402,000.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>403,638,600.00</b>	<b>428,402,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	403,638,600.00	405,553,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,638,600.00	405,553,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	22,848,400.00

132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		22,848,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>403,638,600.00</b>	<b>428,402,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>403,638,600.00</b>	<b>428,402,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>403,638,600.00</b>	<b>416,591,830.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	268,752,321.00	307,876,788.00
210101	Үндсэн цалин	169,056,161.00	199,856,262.00
210102	Нэмэгдэл	70,378,588.00	84,470,938.00
210104	Урамшуулал	16,485,842.00	23,549,588.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,841,279.00	38,889,542.00
210201	Тэтгэврийн даатгал	33,841,279.00	26,563,442.00
210202	Тэтгэмжийн даатгал		3,081,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,465,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал		616,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал		6,163,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,025,200.00	22,623,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,557,723.00	2,338,284.00
210302	Түлш, халаалт	25,067,477.00	19,991,116.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	294,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,611,400.00	1,645,700.00
210401	Бичиг хэрэг	136,700.00	136,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,035,300.00	1,069,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112,300.00	112,300.00
210404	Ном, хэвлэл	78,100.00	78,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249,000.00	249,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	64,204,200.00	40,400,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,200.00	2,201,500.00
210502	Хоол, хүнс	63,437,700.00	36,758,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693,300.00	1,441,300.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	227,600.00	180,000.00
210604	Урсгал засвар	227,600.00	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,400.00	312,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,400.00	112,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,644,600.00	4,663,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,644,600.00	4,663,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>11,810,170.00</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	11,810,170.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,810,170.00

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	252,556,459	748,641,934
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>122,504,224</b>	<b>373,581,251</b>	<b>252,556,459</b>	748,641,934
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	252,556,459	748,641,934
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	252,556,459	748,641,934
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(4,636,837)	(4,636,837)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>122,504,224</b>	<b>373,581,251</b>	<b>247,919,622</b>	744,005,097
Тайлант үеийн үр дүн	-	-	93,655,891	93,655,891
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224	373,581,251	341,575,513	837,660,987

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	433965500	416591830
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	433965500	416591830
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	433965500	416591830

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	308152300	307876788
210101	Үндсэн цалин	195419600	199856262
210102	Нэмэгдэл	90827900	84470938
210104	Урамшуулал	21904800	23549588
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41600600	38889542
210201	Тэтгэврийн даатгал	29274500	26563442
210202	Тэтгэмжийн даатгал	3081500	3081500
210203	ҮОМШӨ-ний даатгал	2465200	2465200
210204	Ажилгүйдлийн даатгал	616300	616300
210205	Эрүүл мэндийн даатгал	6163100	6163100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28229800	22623400
210301	Гэрэл, цахилгаан	3197300	2338284
210302	Түлш, халаалт	24632500	19991116
210303	Цэвэр, бохир ус	400000	294000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1779400	1645700
210401	Бичиг хэрэг	136700	136700
210402	Тээвэр, шатахуун	1203300	1069600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	112300	112300
210404	Ном, хэвлэл	78100	78100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	249000	249000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48859700	40400900
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2234200	2201500
210502	Хоол, хүнс	45184200	36758100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1441300	1441300
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	182100	180000
210604	Урсгал засвар	182100	180000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	343600	312000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143600	112000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000	200000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4676400	4663500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4676400	4663500
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	433965500	416591830
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	405553600	395867900
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405553600	395867900
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	28411900	20723930
132001	Орон нутгийн төсвөөс	28411900	20723930
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1	1
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	1	1
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Т.Тогтохбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч дотоод хяналтын багийн үйл ажиллагааг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-ноос 2021 оны 03 дугаар сарын 17-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батжаргал, гэрээт аудитор Д.Цогзол хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын үеийн хөл хорио тогтоолт, нягтлан бодогчийн ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны 03 сарын 9-ны өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлж хуулийн хугацаа хоцроосноос зэргээс хамаарч аудитын тайлангийн хугацаа хоцорсон болно.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшилд анхаарч, хамран сургах тойргийн 2-5 насны хүүхдүүдэд үндсэн болон хувилбарт хэлбэрээр сургалт явуулж сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ. Байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь:

- ✓ Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- ✓ Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- ✓ Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- ✓ Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэх
- ✓ Сумын 2-5 насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулан, сургуулийн өмнөх боловсролд 5-н настай хүүхдийг бүрэн хамруулж, цэцэрлэгийн хамран сургалтыг 0,3 хувиар ахиулах
- ✓ Үндсэн болон хувилбарт, явуулын чиглэлээр үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах
- ✓ Цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөжүүлж, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлж сайжруулах
- ✓ Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол шийдвэр, аймаг, суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*

- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БШУЯ-наас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй, байгууллагын дотоод хяналтын багаас үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинд “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 413314.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4133.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 442887.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4428.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28214.6 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	2657.2	2738.9	81.7
БАРАА МАТЕРИАЛ	31581.4	31403.4	178.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	714868.7	803518.5	88649.8
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>749107.4</b>	<b>837660.9</b>	<b>88553.5</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	465.5	0	465.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<b>1267722.1</b>	<b>1239874.7</b>	<b>27847.4</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1268708.5</b>	<b>1240493.9</b>	<b>28214.6</b>

Авлага дансны үлдэгдэл оны эцэст 2738.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд өмнөх оноос 1896.5 мянган төгрөгөөр барагдаж, Татварт цалингийн ашиг 1862.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл мянган төгрөг болж 178.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 776704.2 мянган төгрөг, оны эцэст 884845.8 мянган төгрөг болж 108141.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр хөрөнгө худалдаж аваагүй. Энэ нь БСУГ-аас 5141.6 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, Дэлхийн Зөн ОУБ-аас 15000.0 мянган төгрөгийн гадна тоглоом, ОНХС-аас 3000.0 мянган төгрөгийн хувцасны шкаф, Дэлхийн банкнаас 55000.0 мянган төгрөг, ОНХС-аас 30000.0 мянган төгрөгийн ариун цэврийн байгууламж нэмэгдсэнтэй холбоотой байна. Хөрөнгө акталж зарлагдаагүй байна.

Өр төлбөр оны эхэнд 465.5 мянган төгрөгийн үлдэгдэл байсан тайлант онд өрөө барагдуулж дууссан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 837660.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эхнээс 89019.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр 93655.8 мянган төгрөгийн үр дүнгээр өссөн, өмнөх оны үр дүнд 4636.8 мянган төгрөг залруулсан байна.

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 138659.0 мянган төгрөгөөр буюу 20 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 138659.0 мянган төгрөгийн орлого нь барилгын өргөтгөл 250000.0 мянган төгрөгөөр хүлээн авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 29573.1 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 41133.5 мянган төгрөгийн зардал нь цалингийн зардал өссөн, ажил олгогчоос НДШ 4850.5 мянган төгрөгөөр өссөн, 8813.4 байр ашиглалттай холбоотой зардал буурсан, 32028.6 мянган төгрөгийн нормативт зардал буурсан, 544.6 мянган төгрөгийн хангамж бараа материал буурсан, 13375.6 мянган төгрөгөөр бараа үйлчилгээний бусад зардал өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 4636.8 мянган төгрөгийн өглөг бууруулсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 428402.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг 428402.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд тусгай зориулалтын шилжүүлгээс 405553.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 22848.4 мянган төгрөгөөр нийт үйл ажиллагааны зардлыг 428402.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 428402.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 405553.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22848.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 428402.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээс 405553.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22848.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 416591.8 мянган төгрөг зарцуулж 11810.1 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт гарган төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 416591.0 мянган төгрөг буюу 97.2% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрөөс хэмнэлт гаргасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1246.7
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	12.9
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	2124.4
Нийт дүн		11810.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар Нийгмийн даатгалын сангаас Жирэмсэн амаржсаны тэтгэмж 4267.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээ хийсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг оруулсан боловч, 80 мэдээлэл дутуу оруулсан байна. Мөн сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, мөн хугацаанд нь оруулсан боловч мэдээлэл дутуу байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Бараа материалын данстай холбоотой Хүүхдийн хоолны нормативт зардлыг 3126.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, холбогдох стандарт, журмыг зөрчиж 1388.0 мянган төгрөгийн хориглосон бүтээгдэхүүн нийлүүлсэн байна гэсэн зөвлөмжийг 80 хувьтай биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Зөвлөмж	1	0	0	1	0	0	80%
акт	1	559.1	1	559.1			100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>559.1</b>	<b>1</b>	<b>559.1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>90</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11032.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1224.5 мянган төгрөгийн хүнсний материалын үнэ төлүүлэх 1 төлбөрийн акт, 9808.4 мянган төгрөгийн алдааг залруулж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитын явцад 4636.8 мянган төгрөгийн өмнөх оны өглөг, 1896.9 мянган төгрөгийн авлагыг бууруулж, Хүнсний материалын үлдэгдэл тоолуулж 3274.7 мянган төгрөгөөр бүртгүүлж залруулсан.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1224.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1224.5 төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2020 оны санхүүгийн тайланд аудит хийхэд хүнсний материалын тооллого хийгээгүй, тооцоо бодож баталгаажуулаагүйтэй холбоотой тайлангийн мөнгөн хөрөнгийн хүнсний зарлага, нярвын тайлангийн баримтаар гарсан хүнсний зарлага зөрүүтэй үлдэгдэл бодитой боловч хүүхдийн хоолны хүнсний материал дутсантай холбоотой 1224.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн хуулийн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилтэй холбоотой 1224.5 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт бичих

3. Шилэн дансны мэдээллийг хянахад тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг оруулсан боловч, 80 мэдээлэл дутуу оруулсан байна. Мөн сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, мөн хугацаанд нь оруулсан боловч мэдээлэл дутуу, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлээгүй, төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,"; Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар,"; 3.1.16-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### Дотоод хяналттай холбоотой асуудал.

**1.1. Илрүүлэлт:** Байгууллагын даргын тушаалаар "Дотоод хяналтын баг" томилсон ч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгүй, ажлын тайлангүй байгаа нь дотоод хяналт хэрэгжээгүй байна. Мөн байгууллагын бараа материалын тайлан, төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн дотоод хяналт байхгүйгээс төсвийн үрэлгэн зардал гаргажээ.

**1.2. Эрсдэл:** Дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

**1.3. Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д "энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 3.5-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" байгууллагын дотоод журмын 4-ийн 4.16-д "Байгууллага дотоод хяналт шалгалтыг хамт олны хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын тушаалаар батлагдсан /дотоод хяналт шалгалтын журмын дагуу зохион байгуулна. 4.17. Байгууллагын даргын шийдвэрээр орон тооны бус байнгын дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан томилно. гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн хамт олонд мэдээлэх,

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/39/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үенч сумын хүүхдийн цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Зардал хооронд гүйлгэн зарцуулсан Бараа материалын тооллого хийгээгүй улмаас үлдэгдэл зөрсөн	3274.7	Залруулга	Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Нягтлан бодогч	Т.Тогтохбаяр О.Мягмар
2	Авлага, өр төлбөрийг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, мөн авлага үүсгэсэн.	6533.7	Залруулга		
3	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Албан шаардлага		
4	Хүнсний материалын үлдэгдэл дутуу	1224.5	Акт		
5	Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	0	Зөвлөмж		
ДҮН		11032.5			

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**